

Манмин Мэдээ

№ 46 2014 оны 5 сарын 18

GCN (Жи Си Эн) телевиз нь “2014 оны NRB-н чуулга уулзалт болон үзэсгэлэн яармаг”-т оролцлоо



“2014 NRB –н чуулга уулзалт болон үзэсгэлэн яармаг”-т оролцож буй GCN (Жи Си Эн телевиз)-н сурталчилгааны байр (Зураг 1), NRB-н шинэ захирал доктор Жерри Жонсон ярилцлага өгч байгаа нь (Зураг 2 зүүн талаас), И Жей руг пасторын итгэлийн амьдралтай холбогдолтой номуудыг шимтэн сонирхож буй зочид (Зураг 3) И Жей руг пасторын амийн үг сургаал төдийгүй библи үнэн болохыг баталж буй эрх мэдэлт хүчний нөлөө Бурханы баярлах магтаал ба залбирал, гэрчлэл, сургалт соёл урлаг гэх мэт төрөл бүрийн хөтөлбөрүүдийг 24цагын турш цацаж буй тус телевизийг интернетээр болон гар утсаараа(m.gcntv.org)гэсэн хаягаар ороод үзэж болно.

2014 оны 2 сарын 22-25нд АНУ-гийн Нейшвил хотод болсон “2014 NRB (National Religious Broadcasters Дэлхийн Христчин Телевизүүдийн холбоо)”-дын чуулга уулзалт болон үзэсгэлэн яармагт GCN (Жи Си Эн телевиз) оролцсон юм. Тус чуулганд 1400 нэвтрүүлэгийн төв оролцсон бөгөөд NRB-гийн 70 жилийн ой болсон юм.

NRB-гийн удирдах зөвлөлийн дарга доктор Ричард Бот болон бусад удирдах албаны хүмүүстэй уулзаж цаашид GCN (www.gcntv.org)-тай улам гүнзгий хамтран ажиллах гэрээ хийж, мөн энэхүү яармагт оролцогч олон орны Христчин нэвтрүүлгийн төвийн

дарга удирдагчид зочлон ирлээ.

NRB-гийн захирал Жерри Жонсон GCN (Жи Си Эн телевиз)-н сурталчилгааны байранд зочлон ирж дэлгэж тавьсан И Жей руг пасторын номнуудыг онцлон хараад “доктор И Жей руг пасторын номууд манай NRB-гийн үзэсгэлэн яармагт ирсэнд талархаж байна” гэж онцлон тэмдэглэж байв. Мөн тэрээр дэлгээтэй байсан номнууд дундаас “Там” гэсэн номыг хараад “Өнөөгийн ихэнх пасторууд Тамын тухай төдийлөн номлоод байдаггүй” гэж байсан юм.

Мөн Оросын TBN – ийн захирал Игорь Никитин пастор “Би саяхан шинээр нээсэн сувгаараа И

Жей руг пасторын сургаалуудаар шинэ нэвтрүүлэг эхлүүлээд хоёрхон сар болж байгаа ч түүний залбирлаар үй олон хүн эдгэрсэн билээ. Залбирлаар дамжуулан ингэж маш олон эдгэрлийн хүч нөлөө илрэн гардаг номлогч одоог хүртэл И Жей руг пастораас өөр байхгүй байна” гэж хэлсэн юм.

Энэ удаагийн чуулга уулзалт, үзэсгэлэн яармагаар дамжуулан Бразилын Rede TV, Армений Аветис TV, Африкийн TWR (Дэлхийн Радио шугам сүлжээ), зэрэг дэлхий дахинаа тэргүүлж буй олон христчин радиогын төв, телевизүүдтэй хамтран ажиллахаар гэрээнд гарын үсэг зурав.

Зурган мэдээ

Нисси оркестр 22 жилийнхээ ойд зориулж онцгой тоглолт хийв



2014 оны 3 сарын 2ны ням гаригын Эзэний өдрийн үдээс хойшхи мөргөлд солонгосын анхны мэргэшсэн, магтаалын оркестр болох Нисси Оркестр (Удирдаач Жу гуан хёон ахлагч) байгуулагдсаны 22 жилийн ойн баярыг тохиолдуулан “Алдрыг өргөө”, “Итгэлээрээ алхаж ирсэн зам” гэсэн магтан дуугаар онцгой тоглолт хийж Бурханд алдрыг өргөв.

Японы Ида Манмин сүмийн 20 жилийн ойн мөргөл

2014 оны 2-р сарын 23нд Японы Ида хотод байрлах Ида Манмин сүм (хариуцагч пастор Юү Син Гил) байгуулагдсаны 20 жилийн ойн баярын мөргөлд Манмин бүх салбар сүмийн ерөнхий удирдагч И Хи сон пастор оролцон сургаал айлдлаа.

Энэ өдөр Хоккайдогаас Окинава хүртэл олон салбар сүмүүдээс пасторууд, итгэгчид хүрэлцэн ирж оролцсон юм. Баярын цуглааны 1-р хэсэгт Манмин төв сүмийн харьяа “Эрх мэдэлт хүч” баг тоглолтоо сонирхуулж, Ида Манмин сүмийн нэгдсэн найрал дууны баг, Солонго хөгжмийн хамтлагын тоглолтын дараа И Хи сон пастор “Үр жимс” сэдвээр сургаал айлдсан юм. Мөн баярын цуглааны 2-р хэсэгт Японы өнцөг булан бүрээс ирсэн салбар сүмүүдийн урлагын багуудын ойн баярын мэндчилгээ хүргэсэн тоглолтоор Эзэнд алдрыг өргөв.

Түүнчлэн 2 сарын 22 И Хи сон пастор нь И Жей руг пасторын залбирч өгсөн гар алчуураар (Үйлс 19:11-12) эдгэрлийн залбирал хийсэн юм. Тус цуглаанд оролцогчид Ариун Сүнсний галыг авч, сульдах өвчин, хугарсан хөл, үе мөч, мөрний өвчин зэрэг маш олон хүн эдгэрэн Бурханд алдрыг өргөсөн юм.



Бурханы Хайр

“Бурханы биднийг хайрладаг хайрыг нь бид мэдэж, итгэдэг. Бурхан бол хайр мөн. Хайрын дотор байгч нэгэн нь Бурханы дотор байж, Бурхан түүний дотор байна” (1 Иохан 4:16).



И Жей руг Тэргүүн пастор

Бид үзэсгэлэнт сайхан байгаль, түүнд дотор орших сайхан бүхнийг хараад сэтгэл тайвширч аз жаргалыг мэдэрдэг билээ. Хэрэв тийм бол бид зүрх сэтгэлдээ эдгээр бүх л үзэсгэлэнтэй зүйлс болон сайн ба хайрын уг үндэс болсон Бурханы зүрх сэтгэлийг бий болговол хэр зэрэг аз жаргалыг мэдрэх вэ!

Бурханы хайр бол зовлонг зайлуулах амар тайван ба, харанхуйг хөөн зайлуулах итгэл найдвар, ба гэрэл гэгээ, итгэл алдан, цөхөрч, зүрх сэтгэл нь шархалсан нэгнийг зоригжуулах хүчний эх ундарга юм. Мөн уйтгар гунигийг зайлуулах баяр хөөр, таны бүх нулимсыг арчин өгөх тайтгаруулал, сульдэн доройтох үед тань сэтгэлийг тэнхээжүүлдэг амийн эх үүсвэр билээ. Энэ мэт үзэсгэлэнтэй хайр бол бидэн рүү хандсан Бурханы төгс хайр юм.

1. Хүн төрөлхтөнийг дасгалжуулан боловсруулж, жинхэнэ үр хүүхдээр удирдаж өгдөг Бурханы хайр

Бурхан анхны хүн Адамыг бүтээж төрөл бүрийн үзэсгэлэнтэй цэцэг, мод, ургамалтай Еден цэцэрлэг аваачсан билээ. Тэнд маш гайхалтай, сэтгэл хөдлөм, үзэсгэлэнтэй ан амьтад энэ тэндгүй гүйлдэж, хаа сайгүй амтаг жимс арвин ихээр ургасан байдаг байлаа.

Мөн Адамын төлөө Бурхан түүнд Ева гэдэг үзэсгэлэнтэй маш сайн туслагч, өгсөн юм. Адамыг ганцаардаж байгаа нь мэдрэгдээд түүнд туслагчыг өгсөн бус Бурхан Өөрөө маш урт хугацааны турш ганцаар оршиж байсан бөгөөд Бурхан урьдаас төлөвлөн түүнд туслагчыг өгсөн хайрын сэтгэл байлаа.

Анхны хүн Адам нь Еватайгай хамт, бидний төсөөлшгүй сайхан дээд зэргийн орчин нөхцөлд Бурхантай хамт байж, бүх бүтээлийн дээд оргил болохынхоо хувьд агуу эрх мэдлийг эдлэн амьдарч байлаа. Гэвч жинхэнэ үр хүүхэд болоход арай

дутагдалтай зүйл байсан юм. Бурханы зүгээс хүнийг дээд зэргээр хайрлаж байгаа ч Адам Бурханы хайрыг чин сэтгэлээсээ мэдэрч чаддаггүй байсан учраас Бурханы жинхэнэ хүүхэд болж харахан чадаагүй юм.

Бурханы өгсөн бүхэнд Адам сэтгэл хангалуун тааламжтай, маш сайхан байсан ч бүх зүйлийг тэр өөрийн хүч хөдөлмөрөөрөө олж аваагүй, ямар ч хичээл зүтгэл гаргаагүй учраас Бурханд чин сэтгэлээсээ талархаж, ач тусыг нь үнэлж чаддаггүй байсан байна. Мөн тэр хэзээ ч зовлон үзээгүй тул зовлон гуниг, үхэл хагацал гэж юу болохыг ч мэддэггүй байжээ. Тэр үзэн ядалт гэдгийг мэдэхгүй тул жинхэнэ хайрын үнэ цэнийг ч бас мэддэггүй байв.

Тиймээс Адам, Ева хоёр могойн сорилтонд унаж, сайн мууг мэдүүлэх модны жимсийг идсэн юм. Бурхан тэдэнд айлдахдаа, “Чи түүнээс идсэн тэр өдөртөө л зайлшгүй үхнэ! (Эхлэл 2:17)” гэж айлдсан билээ. Гэвч тэд “үхэл” гэдэг яг юу болохыг мэддэггүй байсан. Тэгвэл Бурхан тэднийг сайн мууг мэдүүлэх модны жимснээс иднэ гэдгийг мэдэхгүй байсан юм болов уу? Ердөө ч үгүй. Харин ч Тэр бүгдийг нь урьдаас мэдэж байсан ч Адам Ева хоёрт өөрсдөө чөлөөт сонголт хийх эрх чөлөө байсан бөгөөд энд хүн төрөлхтөнийг дасгалжуулан боловсруулах төлөвлөгөө нууцлагдан байсан юм.

“Хүн төрөлхтөнийг дасгалжуулан боловсруулна” гэдэг нь бид энэ дэлхийд нулимс, уйтгар гуниг, өвчин зовлон, үхэл хагацал гэж юу болохыг үзэж, мэдрсэнээр жинхэнэ аз жаргал, баяр баясгалан ямар их үнэ цэнэтэй, эрхэм нандин зүйл болохыг чин сэтгэлээсээ ойлгон Тэнгэрийн оронд жинхэнэ аз жаргалтай байж чадах юм. Ингэж Бурхан Еден цэцэрлэгтэй харьцуулшгүй үзэсгэлэнтэй үүрд мөнх амьдрах Тэнгэрийн оронд бидэнтэй хамт хайраа хуваалцахыг хүссэн билээ.

Эцэст нь, Адам, Ева хоёр ч өөрсдөө сонголтоо хийж Бурханы үгэнд дуулгаваргүй байсан учраас Еден цэцэрлэгээс хөөгдөж, Адам бүх зүйлийг захирах эрхээ алдаж, түүний эрх мэдэлд байсан амьтан, ургамал хараагдсан билээ. Энэ дэлхий үзэсгэлэнтэй сайхан байсан бол хогийн ургамал, өргөс халгай ургаж эхэлсэн бөгөөд энэ үеэс хойш хүн хүнд хүчир хөдөлмөр хийж үр шимийг нь хүртдэг болсон юм.

Хэдийгээр Адам, Ева хоёр дуулгаваргүй байснаараа энэ дэлхий рүү хөөгдсөн ч Бурхан Еден цэцэрлэгээс тэс өөр энэ ертөнцөд амьдрах болсон тэдний биеийг хамгаалж арьсан хувцас хийж өмсгөсөн юм (Эхлэл 3:21). Бурхан хол газар явуулж

байгаа хүүхдээ сайн сайхан болоод, илүү их ухаан суугаад ирнэ дээ гэсэн эцэг эхийн сэтгэлээр хандсан. Гэвч хүн төрөлхтөнийг дасгалжуулж эхлэх тэр үеэс эхлэн хүмүүс Бурханы сайхан сэтгэл, хайрыг мартсаар асар хурдацтайгаар гэм нүгэлд автаж, Бурханаас холдсон юм (Ром 1:21-23).

2. Өнө эртнээс Есүс Христийг бэлдсэн Бурхан

1 Тимот 2:4 уншвал, “[Бурхан] Тэрээр бүх хүмүүсийг аврагдаасай, үнэний мэдлэг уруу ирээсэй гэж хүсдэг” гэсэн байдаг. Бурханы хайр тусгай цаг үед онцгойлон бэлдсэн хүмүүст өгөгдсөн юм биш. Бурхан бүх хүмүүсийг аврахыг хүсдэг. Тэр авралын үүдийг нээж, Түүнийг эргэж, аврагдаж байгаа хүмүүсийг хараад маш их баярлаж, чин сэтгэлээсээ халуун дотноор хүлээн авдаг юм.

Энэ мэт Бурханы хайр нь эцсийн үе хүртэл бүх хүний төлөө авралын үүдийг нээж өгсөн юм. Есүс Христ бол Бурханы цорын ганц хүү бөгөөд Түүний амь, ариун цусаар гэмт хүмүүсийн гэм нүглийг төлсөн юм. Тэр гэмт хүмүүсийн өмнөөс тэднийг аврахын тулд гэмийн төлөөсийг нь төлсөн юм. Еврей 9:22т “... цус урсгахгүйгээр ямар ч уучлал байхгүй ажээ” гэж айлдсанчлан Бурхан Есүсийн ариун, эрхэм нандин, үнэ цэнэтэй цусыг хүн төрөлхтөний бүх гэмээс нь чөлөөлөхийн тулд урсгасан юм. Эцэст нь, Есүс Христ загалмайд цовдлогдсон ч Тэрээр ямар гэм нүгэлгүй байсан учраас үхлийхүчийг ялан дийлж, гурав хоногийн дараа үхлээс дахин амилснаар билээ. Ингэж л Тэр авралын замын үүдийг нээж өгсөн юм.

Ихэнх эцэг эхчүүд үр хүүхдээ хайрлахдаа нүдний цөцгий мэт хайрлана гэдэг. Мөн хүүхдүүд нь тэдний хувьд өөрсдийнх амь амьдралаас ч илүү үнэ үнэ цэнэтэй гэж боддог. Яг үүнтэй адил бидний Бурхан Аав маань бидний төлөө цорын ганц хайртай Хүүгээ золиос болгосон нь бидэнд хэр хайртай болохоо харуулсан юм. Бурхан Аав маань Эзний цусаар аврагдсан бидэнд үгээр хэлшгүй үзэсгэлэнтэй Тэнгэрийн Орныг бэлдэж байгаа билээ. Түүний хайр ямар агуу, гайхамшигтай вэ!

3. Ариун Сүнсийг бэлэг болгон өгч, тэнгэрийн орон хүртэл замчилж буй Бурханы хайр

Бурханы хайр нь ингээд ч дуусаагүй билээ. Есүс Христийг хүлээн зөвшөөрч гэм нүглээ уучлуулсан хэнд ч Ариун Сүнсийг бэлэг болгон өгдөг. Ариун Сүнс бол Бурханы зүрх, сэтгэл бөгөөд Есүс цовдлогдоод дахин амилсанахаа дараа дээшээ Тэнгэрийн орон руу хөөрөн

одоход Бурхан бидний сэтгэл зүрхэнд Ариун Сүнсийг илгээсэн.

Ариун Сүнс нь бидний төлөө Бурханы үг сургаал судлахад маш их анхаарч, ойлгуулж өгдөг бөгөөд гэм нүглээ хаяхад туслан удирдаг юм. Тэр сул дорой итгэлтэй нэгэнд баг итгэлийг өгч, итгэл найдвараа алдсан нэгэнд Тэнгэрийн орны итгэл найдварыг өгдөг. Яг л ээж хүн хүүхдээ маш их энхрийлэн асарч, анхаарал тавьдаг шиг Ариун Сүнс бидэнд зохистой цагт Бурханы дуу хоолойг сонсгодог болохоор бид унаж, шархдаггүй юм. Биднийг ихэд хайрлаж, Тэнгэрийн орон руу замчилж байдаг Бурханы сайхан сэтгэлийг Ариун Сүнс бидэнд зааж, ойлгуулж өгч байдаг билээ.

Хэрэв бид Бурханыг чин сэтгэлээсээ хайрлавал Тэр биднийг Өөрийн агуу хайраараа хайрлаж, гайхамшигтай амьдралаар амьдруулах болно. Биднийг ямар ч өвчин зовлонгүй эрүүл саруул байлгаж, бүх зүйл бүтэмжтэй сайхан байж, хөгжин цэцэглэж, дэвжин дээшилсэн амьдралаар амьдрах ивээл ерөөлийг өгөх нь гарцаагүй үнэн бөгөөд энэ нь сүнслэг хууль юм. Үүгээр ч зогсохгүй Тэрээр энэхүү ивээл ерөөлөөр, мөн залбирч гуйсан гуйлтынхаа хариултаар дамжуулан Бурханы хайрыг мэдрээсэй хэмээн хүсч байдаг юм.

Та анх Бурхантай уулзаад танд байсан асуудлуудыг шийдэж, гэм нүгэлтэй байсан таныг уучилсан тэр хайранд талархаж байсан байх. Тэр үед та “Би яаж Бурханы энэ их хайр нигүүлслийг хариулах вэ?” гэж бодож байсан бизээ. Ямар ч үхэл хагацал, өвчин зовлон, агаа хорсол, санаа зоволт байхгүй мөнхийн Тэнгэрийн орныг танд өгсөн Бурханы хайранд цочирдон балмагдаж байсан ч байж магадгүй юм. Энэ нь бид сайндаа биш, бид Бурханыг эхлээд хайрласан юм биш харин Тэр биднийг эхлээд хайрлаж, бидэнд Өөрийн гараа сунгасан юм (1 Иохан 4:19).

Бид Түүний хайрыг авахаар тийм их эрхэм нандин, үнэ цэнэтэй биш ч гэсэн гэмт бидний төлөө цорын ганц Хүүгээ өгсөн нь Бурханы хайр юм. Тэр бүх хүнд хайртай, хөхүүл хүүхдээ мартаж чадахгүй эх хүнээс ч илүү их хайрлаж, халамжилж (Исаиа 49:15), мянган жилийг нэг өдөр мэт хүлээдэг юм.

Хайрт итгэлийн ахан дүүс минь, Бурханы хайр үеийн үед, хичнээн их цаг хугацаа өнгөрсөн ч хувируулаагүй юм. Үзэсгэлэнтэй Тэнгэрийн оронд Түүнийг алдаршуулж, Түүнд бүх талархал магтаалыг өргөж байх тэр л өдрийг хүлээж байгаа Бурханы агуу хайрыг чин сэтгэлээсээ мэдрэхийг Их Эзний нэрээр хүсэн гуйн, залбирч байна.

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org

Бурханы хүсдэг залбирал

Лук 22:39-44д Есүс Бурханы хүслийн дагуу заншсан ёсоороо өвдөг сөхрөн сууж, гал халуун залбирдаг байсан тухай гардаг. Түүний залбирал нь бидэнд хэрхэн яаж зөв залбирахыг зааж өгч байгаа юм. Хэдий Есүс Бурханы Хүү байсан ч Тэр чин сэтгэлээсээ залбирах маш сайн жишээг харуулж чадсан. Тэгвэл Бурханы хүүхэд болсон бид яаж залбирах ёстой вэ?

Эш үзүүлэгч Елиа газарт өвдөг сөгдөн толгойгоо хоёр хөлнийхөө хооронд хавчуулан чин сэтгэлээсээ гал халуун залбирдаг байсан. Түүний залбирлаар нь олон жилийн турш ган гачиг болж байсан газарт аадар бороо орж байв. Бид чин сэтгэлийн залбирлыг өргөсөн үед л хариулт, ивээл ерөөлийг авч чадна.

Чин сэтгэлийн залбирал

Абрахам нь Бурханд хувирашгүй, төгс итгэдэг байсан учраас Бурханы үгэнд дуулгавартай байж, эргэлзэж байсан удаа байгаагүй юм. Үхсэнийг хүртэл амилуулах чадалтай агуу хүчирхэг Бурханд итгэдэг учраас ганц хүү Исаакаа тахил болгон шатаа гэхэд ч дуулгавартай байсан билээ (Еврей 11:19). Тиймээс Бурхан түүнийг “Итгэлийн өвөг” гэж өргөмжилж, үр хүүхэд, эрүүл мэнд, эд баялаг, нэр алдар, гээд бүх төрлийн ерөөлийг өгсөн юм.

Олон хүмүүс өөрийн бодол санаанд таарахгүй бол эргэлзэн, гомдоллож, мөн тавгүйтэн дуулгаваргүй байдаг. Мөн итгэдэг гэсэн ч эргэлзэж, салхиар туугдаж байгаа далайн давалгаа мэт итгэхүү, болих уу гэсэн зальхай байдаг. Тиймээс библид эргэлзэж буй хүн Эзэнээс юм авна гэж найдах ч хэрэггүй, хоёр санаа өвөрлөгч нь бүх зүйлдээ тогтворгүй байдаг гэж айлдсан байдаг (Иаков1:6-8).

Иеремиа 33:3-д үзвэл “Намайг дууд, Би чамд хариулж, чиний мэдэхгүй аугаа хүчит зүйлийг Би чамд ярина” гэсэн байдаг. “Намайг дууд” гэдэг нь бид Бурханд хандан залбирахдаа чин сэтгэлээсээ чанга дуугаар дуудан залбирахыг хэлж байгаа юм. Бурханыг чанга дуугаар дуудан залбирахад элдэв бодол санаанд авталгүй, ядрах, нойрмоглохгүйгээр чин сэтгэлийн залбирал хийж чаддаг.

Бид хөлсөө дуслуулан, хүнд хүчир ажил хийж байж үр шимийг нь хүртдэг шиг (Эхлэл 3:19) чанга дуугаар

дуудан залбирч байж залбирлынхаа хариуг авдаг юм. Агаарын хүчийг ноёрхогч дайсан Сатаны эсэргүүцлийг нэвтлэн гарч Тэнгэрийн орон хүртэл Бурхан Аавын сэнтий хүртэл залбирал хийж байж л Ариун Сүнсээр дүүрч зовлон зүдгүүр, сорилт шалгалт зайлж, хүнд хэцүү асуудал бүхэн шийдэгдэнэ. Бүүр цаашлаад чанга дуугаар гал мэт халуун залбирахад бид Ариун Сүнсний эрх мэдэлт хүчийг авч, Есүс Христийн жинхэнэ гэрч болдог.

Чанга дуугаар залбирах

Итгэлийн залбирал

Итгэлтэй болохын тулд биднээс хичээл зүтгэл гарах ёстой ч Бурханаас өгөх тэр итгэлийг авах нь хамгийн чухал юм. Бурханы өгөх энэ итгэл бол үйлс дагуулдаг сүнслэг итгэл юм. Хэрэв бидэнд ийм сүнслэг итгэл байвал Марк 11:24т “Тийм учир Би та нарт хэлье. Та нар юуны төлөө залбирч, гуйж байна, түүнийгээ авсан гэдэгтээ итгэгтүн. Тэгвэл тэр чинь ёсоор болно” гэж бичигдсэнээр бид хариултаа баталгаатай авах юм.

Бид Бурханд хандан залбирахад Тэрээр хүн тус бүрийн итгэлийн дагуу хариултыг нь өгдөг. Хэрэв бид итгэлээр өсч, ямар ч нөхцөл байдалд эргэлзэлгүйгээр

залбирвал Бурхан бидний итгэлийг хараад хариулт, ивээл ерөөлийг өгч бидний эргэн тойрны бүх зүйл сайн, сайхан болдог. Ингэж гал халуун залбирлыг хураасанаар дээрээс хүч өгөгдөж, гэм нүгэлтэй тэмцэн хаяж, үнэний дагуу дуулгавартай байж, Бурханыг баярлуулах итгэлээр ч өсөх боломжтой болдог байна. Ингэж төгс итгэлийг олж авсан итгэгчдэд тэмдэг гайхамшиг дагалдаж, бузар муу сүнснүүдийг хөөн зайлуулж, харь хэлээр ярьж, хорон муу хүмүүсийг хүртэл босгон байгуулж, үхүүлэх ямарч хор уусан тэдэнд хор болохгүй, өвчтэй хүн дээр гараа тавивал эдгэрэх болно (Марк 16:17-18).

Хэрэв бид ямар нэгэн зүйлд тодорхой зорилго тавиад түүнийхээ төлөө өөрийгөө дайчлан идэвхтэй зүтгэж чадвал хурдан амжилтанд хүрдэг билээ. Харин яг таг нарийн тодорхой зорилгогүйгээр ямар нэг ажил эхлэвэл зөв арга замаар явж чадахгүй, өчүүхэн жаахан асуудал тулгарахад би яах гэж энэ ажлыг эхлүүлэв дээ гэж эргэлзэж тээнэгэлзэхэд хүрдэг.

Бид тодорхой зорилготой байж Бурханд хандан залбирах хэрэгтэй. Хэрэв зүрх маань биднийг яллахгүй бол бид Бурханы өмнө зоригтой байж, гуйсан болгоноо

Түүнээс хүлээн авна гэж Тэр амласан (1 Иохан 3:21-22). Бидний залбирлын зорилго тодорхой, ойлгомжтой байвал тэвчээртэйгээр илүү их гал халуун залбирах болно. Тодорхой зорилготой Бурханы өмнө эр зоригтой байна гэдэг нь Түүний тушаалуудыг чанд сахиж, Түүнд таалагдах үйлсийг л хийхийг хэлнэ. Энэ нь Бурхан бидэнд юу хэрэгтэй байгааг урьдаас мэддэг учраас тэр юм. Бидний зүрх сэтгэлийг Бурхан нягталж үзээд яллах зүйл юу ч байхгүй бол бидний хэрэгцээтэй бүхий л зүйлсээр хангаж дүүргэдэг юм.

Зорилготой залбирал

Хайраар залбирах

Еврей 11:6-г уншвал “Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой” гэсэн байдаг. Энэ үгэнд бид итгэж залбирал болгондоо хариулт авч, Тэнгэрийн оронд шагналыг авна гэдэгт итгэдэг бол залбирна гэдэг нь ядрах юм уу залбирахад хэцүү зүйл мэдрэгдэхгүй юм. Мөн түүнчлэн Есүс бүх хүнд амийг өгөхийн төлөө чин сэтгэлээрээ залбирсан шиг бид нар ч гэсэн бусдын төлөө илүү их хайрын сэтгэлээр залбирлаа өргөх хэрэгтэй.

Бурханы хүсэж буй хайрын залбирал бол эхлээд Бурханы хаанчлал болоод зөвт байдлыг эхлээд эрж хайх бөгөөд явж буй сүм чуулганыхаа төлөө, пастор ахлагчынхаа төлөө, олон хүмүүсийн авралын төлөө залбирах залбирал юм. Чин үнэнээр Бурханыг хайрлан, зөвт байдлын төлөө өлсөж цангасан сэтгэлээр сүм чуулган, пастор, ахлагч болон олон хүмүүсийн төлөө залбирах залбирал л чин үнэн хайрын залбирал юм. Түүнчлэн зүрх сэтгэлдээ төгс сүнслэг хайрыг олохын төлөө Бурханы хүслийг ухаарч, Бурханы хаанчлалын төлөөх залбирлыг хэлдэг юм.

Би Францийн Парис хотод амьдардаг хятад хүн билээ. 2011 оноос эхлэн гэртээ интернетээр Манмин төв сүмийн мөргөлд оролцож И Жей руг пастор Бурханы эрх мэдэлт агуу их хүчийг харуулж байгааг хараад маш их ивээл авсан.

2013 оны эхээр Колумбад 20 гаруй хоног байхдаа Библи судлалын клубд оролцож Клубийнхээ гишүүдэд И Жей руг пасторын залбирал хийж өгсөн гар алчуур (Үйлс19:11-12), мөн Муан амтат усны (Ег15:25) тухай ярьж, 10 жилийн турш цусны даралт ихсэх өвчнөөр шаналж байсан өвчнөөсөө И Жей руг пасторын залбирлаар эдгэрсэн тухайгаа гэрчлэн өөрийн зургаа үзүүлсэн билээ.

Тэнд сайн явж чаддаггүй нэгэн эмэгтэй байсан ба тэр эмэгтэй И Жей руг пасторын сургаалуудыг Enlace TV (Эн Ла Сэ ТВ)-р сонсож байсан тухайгаа ярьж байв. Түүний аарцаг нь хазайсан учраас өвдөгөө нугалж чаддаггүй болсон ба баруун өсгий нь газарт хүрдэггүй болсон байв. Цугларалт дуусахад тэнд байсан итгэгчид тэр эмэгтэйн төлөө И Жей руг пасторын залбирал хийж өгсөн гар алчуураараа (Үйлс19:11-12) залбирч өгөхийг надаас хүсэхэд урьд өмнө нь олон хүний өмнө чанга залбирал хийж өгч байгаагүй учраас тэр үед би эргэлзэж байлаа. Гэвч тэд надаас итгэлээрээ залбирч өгөхийг дахин дахин гуйхад би Ариун Сүнсээр дүүрсэн юм.

Яг л тэр үед би анх И Жей руг пастораас гар алчуур авах гэж байхдаа залбируулсан тэр залбирал нь миний гар утсанд хадгалаатай байсан юм. Тийм ч учраас хүч ба урам зоригтойгоор зүрх сэтгэлдээ “Бүхнийг чадагч агуу хүчит Бурхан Аав минь! Хэдийгээр би дутагдалтай ч гэсэн Бурхан Аавын хүслийг дагамаар байна. Энэ хүүхдээрээ Та Өөрийн алдрыг илчлэн харуулаач! Та

эдгээр хүүхдүүдийнхээ итгэл болоод чин сэтгэлийг хараад энэ эмэгтэйд нөлөөлж өгөөч” гэж залбирлаа.

Түүний дараа тэнд байгаа бүх хүмүүсийг хамтдаа залбирахыг уриалж, гар утсанд байгаа хятадаар орчуулсан И Жей руг пасторын залбирлыг даган залбирал хийж өгсөн юм. Би түүний өвчтэй хэсэгт амтаг усыг цацаж өгсөн юм. Түүний дараа гайхамшигтай зүйл бий болсон юм. Тэр эмэгтэй бидний нүдний өмнө цэх алхаж, мөн нуруу нь тэгширч, өвдөг нь нугардаг болсон юм. Халлелүяа!

Франц руу буцах замдаа миний сууж байсан онгоцыг тойроод 30 минутын турш солонго татахыг харсан. Бурхан яг одоо надтай хамт байгаа юм байна гэдгийг мэдээд маш их аз жаргалтай болж билээ. 2014 онд бас нэг аз жаргалтай, гайхамшигтай зүйл тохиолдсон юм. Хятадын Чондугаас ирсэн Рю Чүн хуа эгч дүүд сайн мэдээг танилцуулан И Жей руг пасторын номыг өгөөд интернетээр түүний сургаалуудыг сонсохыг зөвлөсөн. Түүний дараахан тэр охин гайхалтай зүйлийг мэдэрсэн юм.

2014 оны 1 сарын 7нд тэр савны хавдарын мэс засал хийлгээд их хэмжээний цус алдсаар байсан байна. 2014 оны 1 сарын 18, 20, 27 нд гурван удаа яаралтай эрчимт эмчилгээ хийлгэсэн ч цус алдалт зогссонгүй. Би түүнд Эзэний өдрийг ариунаар сахихын чухлыг зааж байсан. 2014 оны 2 сарын 2нд өглөө эртлэн босож Эзэний өдрийг сахихаар Манмин төв сүмийн Өглөөний Хүндэтгэлийн цуглаанд интернетээр оролцож, И Жей руг пасторын өвчин эдгээх залбирлыг авчээ. Яг тэр үед түүний сав нь гадагшаа гарч байгаа юм шиг аймшигтай их өвдсөн байна. Удалгүй түүний мэс засалд хэрэглэж байсан шархны боолт, марль гадагшаа гарсан байхыг мэдээд их гайхжээ. Тэгээд л түүний цус алдалт нь зогссон байна. Халлелүяа!

Одоо тэр эгч дүү үнэхээр аз жаргалтай итгэлийн амьдралаар амьдарч байгаа билээ. И Жей руг пасторын номнуудыг уншиж, 5 дахь өдрийн шөнийн мөргөлд оролцож, хүмүүст сайн мэдээг тараадаг хүн болж өөрчлөгдсөн билээ. И Жей руг пасторын цаг хугацаа, орон зайг даван гарсан залбирлаар дамжуулан намайг эдгээж, эрх мэдэлт хүчийг бусдад номлох агуу гэрчлэлтэй болгож өгсөн Бурхандаа бүхий л алдар, магтаал, талархалыг өргөж байна!

“Бурханы эрх мэдэлт хүчийг бусдад зарлан тунхаглахдаа би аз жаргалтай байдаг”



Пон ри жү итгэгч, Парис, Франц

“Би үр хүүхэдтэй болоод зогсохгүй хүүхдийн маань хүйс нь хүртэл өөрчлөгдөх ерөөлийг авсан”

Чой Юүн ёон сүмд үйлчлэгч (Ямагата Манмин сүм, Япон)

1990 онд Жү Жэ гю ахлагч бид хоёр гэрлэсэн юм. Тэр үед нөхөр маань Японы Сэндай Ерөнхий консулын газар ажиллаж байсан. Гэрлээд 5 жил болсон ч би хүүхэдтэй болж чадахгүй байлаа. Би 7 сартай дутуу төрсөн болохоор төрөлхийн сул дорой биетэй, мөн зүрхний хагалгаанд орж байсан.

1995 оны 5 сард И Жей руг пасторын залбирлаар үе мөчний архаг өвчнөөсөө эдгэрсэн ээжийнхээ зөвлөгөөг даган Манмин төв сүмийн Сэргэлтийн цуглаанд оролцохоор ирсэн юм. И Жей руг пасторын залбирлаар дунд чихний идээт үрэвсэлтэй, эдгэрэхэд маш хэцүү өвчин маань эдгэрч мөн үр хүүхэдтэй болох ерөөлийг авч гурван хүүхэдтэй болсон.

2000 оны 1 сард гуравдахь хүүхэд

болох Жү га ёон эгч дүүсийг тээгээд 6 сартай байхдаа эход харуулахад эрэгтэй хүүхэд болохыг нь мэдсэн. Энэ үед ээж маань миний төлөө санаа зовж байгаа даа гэж гэнэт бодогдож байлаа. Харь газар хүний нутагт сул биетэй байж хүүхэд өсгөнө гэдэг маш хэцүү гэж ээж маань үргэлж санаа зовдог байсан. Харин одоо гурав дахь хүүхэд нь гэдсэнд, тэгээд хүү болохоор өсгөхөд бүр ч их хэцүү санагдаж байсан байх.

Тиймээс би хүү гэж мэдсэн цагаасаа эхлээд л залбирч эхэлсэн. Тэгээд хүүхэд бүрэлдүүлэгч нь Бурхан бөгөөд хүнийг бүтээгч нь ч Бурхан тул би И Жей руг пастораас залбирал авбал хүүг охин болгож өгнө гэсэн итгэл төрсөн юм. Тэгээд би Солонгос руу явж И Жей руг пасторын залбирлыг аваад Япон

руу буцаж байхдаа зүрх сэтгэл минь амар тайван, баяр хөөрөөр дүүрч байлаа. Тэгээд дараа сард нь хоёрдугаар сард шүү дээ, дахин эход харуулахад хүү биш охин байна гэж байсан. 2000 оны 5сард би хөөрхөн үзэсгэлэнтэй эрүүл саруул охинтой болсон юм. Одоо миний охин Жү га ёон эгч дүүс 8-р ангид сурдаг. Тэр ангийн дарга бас багш нарынхаа итгэл, хүндэтгэл, магтаалыг хүлээсэн сайн сурагч бөгөөд Бурханд алдрыг өргөж сүмийн Angel Glory Worship багт бүжиглэдэг. Надад гурван сайхан эрхэм, үнэ цэнэтэй хүүхдийг бас хүүг охин болгон өөрчилж өгсөн Бурхандаа бүхий л алдар магтаал хүндэтгэлийг өргөж байна.



Урд эгнээнд Жү Жэ гю ахлагч, Чой Юүн ёон сүмд үйлчлэгч Арын эгнээнд, Ууган хүү Жү Ши ёон, охин Жү Га ёон, бага хүү Жү Дэ ёон

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь			залбирал цагийн хуваарь			Манай хаяг:
Мөргөл	Цаг		Ангилал	Цаг	Удирдагч	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг	10: 30	Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч	Чуулганы утас: 976-11-351437
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг	11: 30				
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг	18: 00	Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч	Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг	21: 30				
Хүүхдийн цуглаан	Ням гариг	09: 00	Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч	E- шуудан : power3712@gmail.com
Сурагчдын цуглаан	Бямба гариг	15: 00				
Залуучуудын цуглаан	Мягмар гариг	17: 00				

Mongolian
Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм
Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин